



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2012 оны 05 дугаар
тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах болон хавсралтыг шинэчлэн
батлах тухай**

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.7 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг шинэчлэн баталсугай.

2.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах” гэсэн хоёр дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.22 дахь дэд заалт нэмсүгэй:

“2.1.22.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын дарга.”

3.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах” гэсэн хоёр дахь хэсгийн 2.1.20 дахь дэд заалтын “Ерөнхий захирал,” гэсний дараа “гишүүн” гэж нэмсүгэй.

4.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын дараах заалт, дэд заалтыг доор

дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2.2.12 дахь дэд заалт:

“2.2.12.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт;”

2/3.6 дахь заалт:

“3.6.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалд томилогдох этгээд, цаашид тухайн байгууллагын зохион байгуулалтын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр мэдүүлэг гаргах албан тушаалд томилохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч, холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт нэн даруй хүргүүлнэ.”

3/4.6 дахь заалт:

“4.6.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт төрийн албан хаагчийн анкет, ажлын байрны тодорхойлолт, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.”

5.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2.2.13 дахь дэд заалтын “ерөнхий менежертэй” гэснийг “төсвийн шууд захирагчтай” гэж, “ерөнхий менежер” гэснийг “төсвийн шууд захирагчид” гэж тус тус өөрчилсүгэй.

6.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2.2.14 дэх дэд заалтын “, туслах, бие төлөөлөгч, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан” гэснийг, 3.9 дэх заалтын “, хязгаарлагдмал хариуцлагатай компаниас эзэмшиж байгаа ногдол хувь нь тухайн албан тушаалтны нэг жилийн цалингийн хэмжээнээс бага” гэсэн хэсгийг тус тус хассугай.

7.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

8.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын
хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын
хавсралт

**ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ
ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**

/Шинэчилсэн найруулга/

Нэг.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргана:

1.1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан /тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;

1.2.Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан /олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;

1.3.улсын төсвөөс санхүүжилт авдаг болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгууллага, хороо, төвийн удирдах албан тушаалтан.

1.4.Монголбанкны газар, хэлтэс /салбар, алба/-ийн захирал, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч-хянан шалгагч, нягтлан бодогч, өр барагдуулах ажилтан, банкны эрх хүлээн авагч.

Хоёр.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан улс төрийн, төрийн захиргааны болон төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны дараах ангилал, зэрэглэлийн албан тушаалтнаас бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргана:

2.1.улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх туслах, бие төлөөлөгч, хэвлэлийн ажилтан;

2.2.Монгол Улсын Их Хурал дахь болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан;

2.3.төрийн захиргааны албаны "ТЗ-1"- "ТЗ-5"-д хамаарах албан тушаалтан;

2.4.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албаны "ТҮШУ-4", "ТҮМБ-4", "ТҮМБ-5", "ТҮМБ-6", "ТҮЭМ-5", "ТҮСУ-7", "ТҮСУ-8"-д хамаарах албан тушаалтан;

2.5.боловсрол, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших “ТҮМБ-7”, “ТҮМБ-8”, “ТҮЭМ-6”, “ТҮЭМ-7”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан;

2.6.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “ТТ-1”-“ТТ-10”-д хамаарах албан тушаалтан болон “ТТ-11”-ийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс бусад албан тушаалтан;

2.7.батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

2.8.онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “ТТ-1”-“ТТ-11”-д хамаарах албан тушаалтан;

2.9.цагдаагийн байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

2.10.хил хамгаалах байгууллагын “ТТ-1”-“ТТ-10”-д хамаарах албан тушаалтан;

2.11.тагнуулын байгууллагын “ТТ-1”-“ТТ-9”-д хамаарах албан тушаалтан;

2.12.Тахарын албаны “ТТ-1”-“ТТ-11”-д хамаарах албан тушаалтан;

2.13.хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн “ТТ-1”-“ТТ-13”-д хамаарах албан тушаалтан;

2.14.шүүхийн шинжилгээний байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан болон “ТТ-9”, “ТТ-10”-ын шинжээчээс бусад албан тушаалтан;

2.15.төрийн захиргааны албаны “АА-9”-“АА-11”-д хамаарах албан тушаалтан;

2.16.Авлигатай тэмцэх газрын туслах ажилтан;

-----oOo-----

Тайлбар: “ТЗ” ангилалд төрийн захиргааны албан тушаалтан, “ТТ” ангилалд төрийн тусгай албаны албан тушаалтан, “ТҮШУ” ангилалд шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮМБ” ангилалд мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮСУ” ангилалд соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮЭМ” ангилалд эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “АА” ангилалд Монгол Улсын Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага болон тэдгээртэй адилтгах байгууллагын ажлын албаны албан тушаалтан.